



2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.39 дэх заалт, 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Эдийн засгийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Монгол Улсын Хөгжлийн банканд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл /М.Баярмагнай/, гүйцэтгэх захирал /Б.Батбаяр/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /Б.Мөнх-Очир/-т даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Хишигтогтох/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.БҮРЭНБАТ



\\10.10.10\Bichig_Khereg\Tushaal\2019\A Tushaal\0502GAG4.Docx

070455



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товчёр	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	8

БҮЛЭГ 1.ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО БҮРЭН БҮРДЭЭГҮЙ БАЙСАН ТӨДИЙГҮЙ БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ БҮРЭН УЯЛДААГҮЙ БАЙНА

Оршил	10
Эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрэн бүрдээгүй байхад МУХБ-ны тухай хууль /2011 он/ батлагджээ	11
МУХБ-ны зээл олгох үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулах эрх зүйн зохицуулалт орхигдсон байна	12
МУХБ-ны зорилго, зорилтууд хууль тогтоомжид нийцэж буй хэдий ч 2016 оныг хүртэл уг зорилтыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөгүй ажиглаж байжээ.....	14
Банкны захиргааны нэгжийн орон тоо банкны үйл ажиллагаатай бүрэн уялдаагүй байна	15
Арвилан хэмнэлттэй ажиллах зарчмыг хангаагүй, үр ашиггүй зарцуулалт хийж иржээ.....	17
Худалдан авах ажиллагаанд мөрдөж буй журмын зохицуулалт хангалтгүй байгаа нь арвилан хэмнэлтгүй худалдан авалт хийгдэх нөхцөлийг бүрдүүлж байх тул ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөх нь зүйтэй байна	19

БҮЛЭГ 2. МУХБ 2012-2016 ОНУУДАД ТООЦОО СУДАЛГААГҮЙГЭЭР ЭХ ҮҮСВЭР ТАТАЖ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГЫГ ЗОХИСГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭС ИХ ХЭМЖЭЭНИЙ АЛДАГДАЛ ХҮЛЭЭСЭН БАЙНА.....

Оршил	22
Евро бонд:	22
Чингис бонд:	22
Самурай бонд:	23
Кредит Свисс банкны зээл:	23
Каргилл санхүүгийн байгууллагын зээл	24
БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл:	24
Бусад эх үүсвэр:.....	24
Бэлтгэл ажлыг бүрэн хангахгүйгээр бонд гаргасан, зарим бондын эх үүсвэр татах үйл ажиллагааны зардал өндөр байгаа нь бодит хүү нэмэгдэхэд хүргэсэн байна	26
2012-2015 онд мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс их хэмжээний орлого олох боломжийг алдаж, 102.1 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн байна	27

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ИЖ БҮРЭН БУС, ЗЭЭЛ ОЛГОЛТОД МӨРДӨГДӨЖ БУЙ ДҮРЭМ, ЖУРМЫН ЗОХИЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Оршил	31
МУХБ-ны санхүүжүүлсэн зарим зээл зорилго, зорилтод нийцээгүй, УИХ-аас батлаагүй хөтөлбөрүүдэд арилжааны банкаар дамжуулан зээл олгосон байна	34
Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй багц	34
МУХБ-ны санхүүжүүлсэн зарим төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.....	37
Зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмуудын зохицуулалт хангалтгүй, арилжааны банкаар дамжуулан олгосон зарим зээл зориулалтын дагуу ашиглагдаагүй байна	54
Зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмуудад нарийвчилсан зохицуулалтууд хангалтгүй байгаа нь зээлийн үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна	56
Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 2018 оны жилийн эцсийн байдлаар 8.5 хувь байна.....	63
Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй багц	63
Арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийн багц	63
МУХБ-наас шууд олгосон зарим зээлийн ашиглалт муу, эргэн төлөлт хангалтгүй, хугацаа хэтэрч байгаа нь төслийн үнэлгээ хангалтгүй хийгдсэнтэй холбоотой байна	64



БҮЛЭГ 4. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО 2017 ОН ХҮРТЭЛ ЗОХИХ ЁСООР БҮРДЭЭГҮЙ БАЙЖЭЭ	73
Оршил	73
Дотоод хяналтын тогтолцоо 2017 оныг хүртэл бүрэн бүрдээгүй байжээ	73
Монголбанкнаас тогтоосон хязгаарлалт, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд хангагдаж байна	74
МУХБ-ны зүгээс зээл ашиглалт, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт 2017 оныг хүртэл хангалтгүй явж иржээ	75
 Холбогдох байгууллагын санал:	77
 Саналд өгсөн тайлбар:	78
 ДҮГНЭЛТ:	82
 ЗӨВЛӨМЖ:	84
 ХАВСРАЛТУУД:	85



Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АПУГ	Актив, пассивын удирдлагын газар
АПУХ	Актив, пассивын удирдлагын хороо
АПХУГ	Актив, пассив хөрөнгийн удирдлагын газар
АТГ	Авлигатай тэмцэх газар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗМС	Зээлийн мэдээллийн сан
ЗТБХБС	Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд
ЗТЯ	Зам тээврийн яам
ЗУХ	Зээлийн удирдлагын хороо
МУЕС	Монгол Улсын Ерөнхий Сайд
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн Банк
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОХУ	Оросын Холбооны Улс
СЯ	Сангийн яам
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УЦС	Усан цахилгаан станц
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс



ХК	Хувьцаат компани
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШДАГ	Хяналт шинжилгээ, дотоод аудитын газар
ХШТГ	Хяналт, шалгалт, тамгын газар
ЭГУЦС	Эгийн голын усан цахилгаан станц
ЭЗХС	Эдийн засгийн хөгжлийн сайд
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭУГ	Эрсдэлийн удирдлагын газар
ЭҮУГ	Эрсдэлийн үнэлгээ, удирдлагын газар
ЭХЯ	Эрчим хүчний яам



Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Банкны газар, хэлтэс, албадын орон тооны харьцуулалт	17
Хүснэгт 2	МУХБ-ны зардлын гүйцэтгэл	18
Хүснэгт 3	Евро бондын зарцуулалт	22
Хүснэгт 4	Чингис бондын нөхцөл	22
Хүснэгт 5	Чингис бондын зарцуулалт	23
Хүснэгт 6	Самурай бондын зарцуулалт	23
Хүснэгт 7	Кредит Свисс банкны зээлийн зарцуулалт	24
Хүснэгт 8	Каргилл санхүүгийн байгууллагын зээлийн зарцуулалт	24
Хүснэгт 9	БНХАУ-ын Хөгжлийн банкны зээлийн зарцуулалт	24
Хүснэгт 10	Ханшийн тэгшитгэлийн алдагдал	27
Хүснэгт 11	Мөнгөн хөрөнгийн цэвэр үлдэгдэл	27
Хүснэгт 12	Мөнгөн хадгаламжийн хүүгийн зөрүүгээс тооцоолсон алдагдсан боломж	28
Хүснэгт 13	Хүүгийн зөрүү бүхий хөтөлбөрүүд	29
Хүснэгт 14	Зээлийн багцын үлдэгдэл. 2012-2017 он	31
Хүснэгт 15	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	32
Хүснэгт 16	“Эрдэнэс Оюу толгой” ХХК-д олгосон зээлийн зарцуулалт	34
Хүснэгт 17	Засгийн газрын тогтоолын дагуу хэрэгжсэн хөтөлбөрүүд	35
Хүснэгт 18	МУХБ-ны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн эвдрэл, гэмтэлтэй замуудын жагсаалт	37
Хүснэгт 19	Замын өртгийг Засгийн газрын 2011 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан жишиг үнэлгээтэй харьцуулан тооцсон байдал	38
Хүснэгт 20	“Шинэ төмөр зам төсөл”-ийн эхлэл санхүүжилтийн зарцуулалт	40
Хүснэгт 21	“Шинэ төмөр зам” төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн зарцуулалт	40
Хүснэгт 22	“Шинэ төмөр зам төсөл”-ийн техникийн зөвлөх үйлчилгээ, хяналтын зөвлөх үйлчилгээний төлбөрийн санхүүжилт	41
Хүснэгт 23	Нийлүүлэгдсэн Төмөр замын зам, засварын машин механизм	42
Хүснэгт 24	Төсөл, арга хэмжээний хуульд тусгагдсан байдал	45
Хүснэгт 25	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй МУХБ-ны санхүүжилтээр Улаанбаатар хотод хэрэгжсэн зураг төслийн ажлууд	47
Хүснэгт 26	Ажлын төсөв баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	48
Хүснэгт 27	Төсөвт өртөг харилцан адилгүй төслүүд	49
Хүснэгт 28	Тусгай зөвшөөрлийн зөрчилтэй гүйцэтгэгчийн мэдээлэл	50
Хүснэгт 29	Тусгай зөвшөөрлийн зөрчилтэй гүйцэтгэгчийн мэдээлэл	50
Хүснэгт 30	Батлагдсан чиглэлд хамаарахгүй сонгон шалгарсан төслийн судалгаа	59
Хүснэгт 31	Арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийн үлдэгдлийн зөрүү	64
Хүснэгт 32	Үндсэн цалингийн харьцуулалт	65
Хүснэгт 33	“ТОСК” ТӨҮГ-т олгосон зээл	67
Хүснэгт 34	Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн дэд бүтцийн судалгаа	70
Хүснэгт 35	МУХБ-ны зохистой харьцааны зарим шалгуур үзүүлэлтүүд	75

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Үл хөдлөх хөрөнгийн харьцуулалт	21



Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Улсын өрийн удирдлага /чиг үүргийн хуваарилалт	11
Дүрслэл 2	“Ди Би Эм Лизинг” ХХК-ийн үндсэн үзүүлэлт	16
Дүрслэл 3	МУХБ-ны 2012-2017 оны орон тооны харьцуулалт	17
Дүрслэл 4	МУХБ-ны 2012-2017 оны зардлын гүйцэтгэл	18
Дүрслэл 5	МУХБ-ны нийт активын хэмжээ	30
Дүрслэл 6	Зээлийн багцын үлдэгдэл	31
Дүрслэл 7	МУХБ-ны зээлийн багцын чанар	32
Дүрслэл 8	“Ухаахудаг-Гацуунсүхайт” чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих төслийн багцын мэдээлэл	39
Дүрслэл 9.	АНУ-ын долларын ханшийн өсөлт	54
Дүрслэл 10	Нийт зээл, ангилал шилжсэн зээлийн дүн	63

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	МУХБ-ны тухай 2011, 2017 оны хуулиудын харьцуулалт	85
Хавсралт 2	Олон улсад үйл ажиллагаа явуулж буй хөгжлийн банкны бүтээгдэхүүн/Instruments	88
Хавсралт 3	Татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн жагсаалт	89
Хавсралт 4	Арилжааны банкнуудад байршуулсан хадгаламж	90
Хавсралт 5	МУХБ-ны 2012-2018 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад орлогын талаарх мэдээлэл	91
Хавсралт 6	Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан ч хэрэгжилт удааширсан ТАХ-ний жагсаалт	92
Хавсралт 7	Авто замтай холбогдуулан гарсан Засгийн газрын тогтоолууд	93
Хавсралт 8	Арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийн үлдэгдлийн зөрүү /Хөтөлбөр тус бүрээр/	94



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг УИХ-ын Эдийн Засгийн байнгын хорооны 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 11/9920 дугаар албан бичиг, Төсвийн Байнгын хорооны 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 9/10647 дугаар албан бичиг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ХЭГ/1880 дугаар албан бичиг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/219 дүгээр тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын Хөгжлийн банкны /цаашид МУХБ гэх/ үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдалд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- МУХБ-ны зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх;
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үр ашигтай, эрсдэлгүй удирдаж байгаа эсэх;
- Зээл олголтын үйл ажиллагаа үр дүнтэй, хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэх;
- Банкны үйл ажиллагаанд хяналтын үр нөлөөтэй тогтолцоо үйлчилж байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад МУХБ-ны 2012-2017 оны үйл ажиллагаа, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр шууд олгосон зээл, Засгийн газрын холбогдох тогтоолуудын дагуу арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийг түүврийн аргаар хамруулж, УИХ-ын 2016 оны 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 42, 219 дүгээр тогтоолуудын хүрээнд МУХБ-аас Сангийн яаманд шилжүүлсэн “улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон зээл”-ийн багцын хувьд төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үйл ажиллагаа нь жил бүрийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар шалгагдсан тул хязгаарлаж, хэрэгжилт хангалтгүй төслүүдийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох чиглэлээр ажиллав.

Аудитын хязгаарлалт

ҮАГ-аас тусгайлан эрсдэлийн болон нийцлийн аудит хийсэнтэй холбогдуулан МУХБ-аас санхүүжүүлсэн дараах төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийг уг аудитад хамруулаагүй болно. Үүнд:

- “Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт “АСЕМ”-ыг зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл, үр дүн”;
- ““Гудамж” төслийн нийслэлд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт”

Мөн хууль, хяналтын байгууллагад шалгагдаж буй, шүүхээс эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа дараах зээл, баримт материалыг аудитад бүрэн хамруулаагүй болно.

- “Мон лаа” ХХК-д олгосон зээл;
- Шинэ төмөр зам төслийн хүрээнд олгогдсон зээл;
- “Эгийн голын усан цахилгаан станц” төсөлд олгосон зээл;
- Халзанбүргэдэй-Солонготын даваа чиглэлийн 100 км автозамын төсөлд олгосон зээл;



**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

- МУХБ-ны үйл ажиллагаа, олгосон зээлийн үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэл түгээхтэй холбоотой зарим гэрээ, баримт материал;

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон зээл олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 6 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнх-Очир удирдаж, аудитын менежер Б.Саруул чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын менежер Л.Эрдэнэчулуун ахлах аудитор Б.Хишигтогтох, Д.Баатархуяг, аудитор М.Доржмаа, И.Туяадарь, Б.Хаш-Эрдэнэ, Э.Уянга, Э.Бүгүнүтэй, Б.Мөнхтуяа, Б.Лхагвацэрэн, Ж.Мөнхбилгүүн, Б.Алтангэрэл нар гүйцэтгэв.

Аудитын эхний үе шатыг 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн хооронд хийж, тайлангийн төслийг Удирдлагын зөвлөлөөр 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцүүлэн, нэмэлт горим гүйцэтгэх төлөвлөгөөг 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр батлуулсан болно.

Аудитын дараагийн үе шатыг 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хооронд хийж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг гүйцэтгэлийн аудитын журмын 8,9,10 дугаар маягтын дагуу бэлтгэж, ажлын баримт материалд хавсаргав.



БҮЛЭГ 1. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО БҮРЭН БҮРДЭЭГҮЙ БАЙСАН ТӨДИЙГҮЙ БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ БҮРЭН УЯЛДААГҮЙ БАЙНА

Оршил

Энэ бүлэгт МУХБ-ны хууль, эрх зүйн орчин, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны зардлын зарцуулалтын талаарх асуудлыг “Зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх” зорилтын хүрээнд авч үзлээ.

УИХ-аас МУХБ-ны тухай хуулийг анх 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр, шинэчилсэн найруулгыг 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдөр тус тус баталсан бөгөөд Засгийн газрын 2011 оны 151 дүгээр тогтоолоор банкны дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг, 2017 оны 123 дугаар тогтоолоор банкны дүрмийг шинэчлэн баталжээ.

МУХБ-ны тухай хуульд /2017 он/ тус банкны эрх зүйн байдлыг “үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1¹-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна” гэж тодорхойлсон байна.

МУХБ нь 2018 оны жилийн эцсийн байдлаар ТУЗ, гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, 5 газар, 3 алба бүхий нийт 158 ажилтантай, 13.4 тэрбум төгрөгийн удирдлагын болон үйл ажиллагааны зардалтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тус банк нь ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх замаар иргэдийг орон сууцжуулах зорилтын хүрээнд “МИК Холдинг” ХК-д хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд тус компанийн 3.1 сая ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 14.9 хувийг эзэмшиж байна.

УИХ болон Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу үйлдвэржилтийг дэмжсэн санхүүгийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бизнес эрхлэгчдийн эрсдэлийг багасгах, санхүүжилтийн өртгийг бууруулах, үйл ажиллагаагаа төрөлжүүлэх зорилгоор “Ди Би Эм Лизинг” ХХК, “Ди Би Эм Ассет менежмент” ХХК гэсэн охин компаниудыг байгуулсан бөгөөд “Ди Би Эм Лизинг” ХХК үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

МУХБ-ны одоогийн гүйцэтгэх удирдлагын баг гүйцэтгэх захирал Б.Батбаяр, тэргүүн дэд захирал Ч.Энхбат, газрын захирал Б.Чойжилжалбуу, Я.Сод-эрдэнэ, Ч.Мөнхбаяр нар нь 2016 оны 9 дүгээр сараас МУХБ-ны ТУЗ-ийн 57, 75, 77, 78, 80 дүгээр тогтоолуудаар, О.Батбаатар 2018 оны 61 дүгээр тогтоолоор тус тус томилогдон ажиллаж байна.

¹ МУХБ-ны тухай хууль /2017 он/ 8.1.Хөгжлийн банк дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

- 8.1.1.төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх;
- 8.1.2.төлбөр тооцоо хийх;
- 8.1.3.баталгаа, батлан даалт гаргах;
- 8.1.4.үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах;
- 8.1.5.зээл авах;
- 8.1.6.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах;
- 8.1.7.компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх;
- 8.1.8.төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- 8.1.9.экспорт, импортын санхүүжилт хийх;
- 8.1.10.төлбөрийн чадварыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор богино, дунд хугацаатай санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх.



Эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрэн бүрдээгүй байхад МУХБ-ны тухай хууль /2011 он/ батлагджээ

1.1 Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 195 дугаар тогтоолоор МУХБ-ыг байгуулахаар шийдвэрлэж, УИХ-аас МУХБ-ны тухай хуулийг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр хэлэлцэн баталсан байна.

1.2 Тухайн үед өр үүсгэхээс эхлээд эргэн төлөгдөх хүртэлх харилцааг нарийвчлан зохицуулсан хууль эрх зүйн орчин бүрдээгүй, Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай /2003 он/, Төсвийн тухай /2011 он/, Төсвийн тогтвортой байдлын тухай /2010 он/, Валютын зохицуулалтын тухай /1994 он/, зэрэг хэд хэдэн хуулиудад өрийн асуудлууд нь салангид байдлаар туссан, Засгийн газрын өрийн удирдлагын бодлого, зохицуулалт нэгдмэл бус байжээ.

Дүрслэл 1. Улсын өрийн удирдлага /чиг үүргийн хуваарилалт/

1.3 Аудитын дээд байгууллагуудын Олон улсын байгууллага /INTOSAI/ -ын дэргэдэх Олон Улсын Хөгжлийн агентлагаас гаргасан удирдамжид заасан тогтолцооны загварт үндэслэн Засгийн газраас хэрэгжүүлж байсан өрийн удирдлагын бүтцийг үндсэн 3 чиглэлээр харьцуулж үзэхэд өрийн стратеги, өр зээлийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрэн бүрдээгүй байжээ.

Урд оффис буюу багцын удирдлага

- Гэрээ хэлэлцээр
- Өр үүсгэх
- Дотоод хөрөнгийн зах зээлийн хөгжил
- Хувийн хэвшлийн түншлэл
- Гадаад түншлэл
- Олон улсын санхүүгийн байгууллагууд

Дунд оффис буюу эрсдэлийн удирдлага

- Өрийн стратеги
- Өр зээлийн хэрэгцээ шаардлага
- Эрсдэлийн шинжилгээ
- Эрсдэлийн үнэлгээ

Хойд оффис буюу бүртгэл, мэдээллийн удирдлага

- Бүртгэлжүүлэлт
- Төлбөр тооцоо
- Тайлагнах
- Гүйлгээний бүртгэл
- Системийн удирдлага
- Нягтлан бодох бүртгэл
- Өрийн статистик мэдээ
- Хөрөнгө, өр төлбөр

1.4 УИХ-аас Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 2 дугаар сард батлагдан гарснаар өрийн нэгдсэн удирдлагатай болох үндэс суурь тавигдсан байна.

1.5 МУХБ-ны тухай хуульд /2011 он/ “Хөгжлийн банк нь энэ хуулийн 8.1²-д заасан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий энэ хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэгтэй ашгийн төлөө төрийн өмчит хуулийн этгээд байна” гэж заасан бөгөөд УИХ-ын баталсан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох зохицуулалттай байжээ.

1.6 МУХБ-ны тухай хууль /2011 он/ батлагдсантай холбоотойгоор Төв банкны тухай хуулийн 2¹ дүгээр зүйл³, Банкны тухай хуулийн /2010 он/ 2¹ дүгээр зүйлийн 2^{1.14},

Шигтгээ 1.

ХБНГУ, Норвеги, Канад, Япон, БНСУ, БНХАУ, Казакстан зэрэг 30 гаруй улс орны Хөгжлийн санхүүгийн байгууллага нь санхүүгийн салбар, аж үйлдвэр, дэд бүтэц, үйлдвэрлэлийн салбарт дунд болон урт хугацааны санхүүжилт олгох, экспортын зээл олгох, баталгаа гаргах, зөвлөгөө өгөх, лизингийн үйлчилгээ үзүүлэх зэргээр улс орны эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх механизм болон ажиллаж байна.

Дээрх улсуудын жишгээс харахад Хөгжлийн банк улс орны эдийн засгийн өсөлтийг хангах, төрөлжүүлэх, шинэчлэлийг дэмжих, нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэгдсэн ажилхааны банк, санхүүгийн байгууллагын санхүүжүүлж чадахааргүй томоохон төслүүдийн урт хугацаанд санхүүжүүлэх үйл ажиллагаа голлон явуулдаг бөгөөд үйл ажиллагааны үр дүнг олж буй ашгийн хэмжээгээр бус нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөө, алдагдалгүй ажиллаж буй эсэх зэрэг үзүүлэлтээр үнэлж дүгнэдэг байна. /Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү/

² МУХБ-ны тухай хууль /2011 он/ 8.1.Хөгжлийн банк нь Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг УИХ жил бүрийн хаврын чуулганаар батална.

³ Төв банкны тухай хуулийн 2¹ дүгээр зүйл Хуулийн үйлчлэх хүрээ “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.”

⁴ Банкны тухай хуулийн /2010 он/ 21 дүгээр зүйлийн 2^{1.1} МУХБ-ны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй



ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.6⁵, ТБОНӨТХ-ийн 2 дугаар зүйлийн 2⁶-д нэмэлт өөрчлөлт тус тус орсноос шалтгаалан дараах хуулийн заалтууд МУХБ-нд хамаарахгүй болсон байна. Үүнд:

- Төв банкны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1-т "Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах арга, хэрэгслийг ашиглаж болно: 1/банкны заавал байлгах нөөц, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох;
- Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т "өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу биелүүлэх";
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Дараах этгээд захиалагч байна", 4.1.1 "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд";
- ТБОНӨТХ-ийн 13 дугаар зүйл "Төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт, ангилал"

1.7 МУХБ-ны тухай хууль /2011 он/ болон МУХБ-ны ТУЗ, гүйцэтгэх удирдлагын баталсан бодлого, дүрэм, журамд дараах асуудлыг нарийвчлан зохицуулаагүй байжээ. Үүнд:

- Үнэт цаас гаргах, зээл авах зэргээр эх үүсвэр татан төвлөрүүлэхдээ уг хөрөнгөөр санхүүжих төслийн үр ашгийн тооцоолол, эргэн төлөлтийн хуваарь зэрэг тооцоо, судалгаанд үндэслэн шаардлагатай хөрөнгийн дүн, хугацааг тодорхойлох;
- Зээл олгох төсөл, хөтөлбөр нь хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрт хамрах эсэхийг тодорхойлох үндэслэл, шалгуур үзүүлэлт;
- Гүйцэтгэх удирдлага банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон удирдлагын чадварыг хангаж ажиллах чадвартай байх шаардлагатай гэж заасан боловч уг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хэн батлах талаар тус тус зохицуулалтгүй байжээ.

1.8 Мөн МУХБ-ны тухай хуулийн /2011 он/ 8.1-т "Хөгжлийн банк нь УИХ-ын баталсан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг УИХ жил бүрийн хаврын чуулганаар батална" гэж заасан нь тус хуулийн 6.1-т "Хөгжлийн банк нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална: 6.1.2-т хараат бус байх" гэсэн зарчимтай зөрчилдөж байжээ.

МУХБ-ны зээл олгох үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулах эрх зүйн зохицуулалт орхигдсон байна

1.9 УИХ-ын 2014 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан "Эдийн засгийн идэвхжиллийг нэмэгдүүлэх арга хэмжээний чиглэл" -ийн 3.3⁷ -д "... Хөгжлийн банкны тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж, өргөн мэдүүлэх"-ийг Засгийн газарт үүрэг болгосон ч тодорхой үр дүн гараагүй байна.

1.10 МУХБ-ны тухай 2011 оны хуулиар эрх зүйн зохицуулалт бүрэн хангагдаагүй, МУХБ-наас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг УИХ-аас жил бүрийн хаврын чуулганаар батлах заалт бүрэн хэрэгжээгүй, МУХБ-ны ашигт ажиллагаа хангалтгүй, зээлийн багцын ангилал буурах, эх үүсвэрийн эргэн төлөлтийг гүйцэтгэхэд хүндрэл учирсан тул УИХ-аас тус хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 2 дугаар сард хэлэлцэн баталжээ.

1.11 МУХБ-ны тухай хуулийн /2011/ он нийт 29 зүйл 71 заалттай байсан бол шинэчилсэн найруулга 32 зүйл, 75 заалттай болж, зээл олгох, төсөл санхүүжүүлэх зарчим шинэчлэгдэн, үйл ажиллагааны хүрээ өргөжих⁸ боломж нэмэгдэж, Монголбанк, Засгийн газрын зүгээс тавих хяналтын тогтолцоо бүрдсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү/

1.12 МУХБ-ны тухай хуульд /2017 он/ МУХБ-наас санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргах нийт санхүүжилтийн дүнгийн 60-аас доошгүй хувийг экспортыг дэмжсэн төсөл, хөтөлбөр

⁵ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.6-д "МУХБ-ны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй",

⁶ ТБОНӨТХ-ийн 2 дугаар зүйл Үйлчлэх хүрээ 2. "Энэ хууль нь. ...Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан Хөгжлийн банкны үйл ажиллагаатай ... холбогдсон харилцааг зохицуулахад үйлчлэхгүй."

⁷ 3.3 Хөгжлийн банкны үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж, засаглалыг сайжруулах, бие даасан байдлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг зохистой болгох чиглэлээр Хөгжлийн банкны тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж, өргөн мэдүүлэх,

⁸ МУХБ-ны тухай хуулийн /2017 он/ 8.1.7.компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх; 8.1.8.төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх; 8.1.9.экспорт, импортын санхүүжилт хийх;



хэрэгжүүлэхэд зарцуулах, тус хуулийн 10.1⁹-д заасан шаардлага хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх, иргэдийн мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа явуулахгүй байхаар заасан байна.

1.13 Эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1¹⁰, 28.10¹¹ -д заасны дагуу Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамаарахаар байна.

1.14 МУХБ-ны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь МУХБ-ны тухай хуулийн /2017 он/ 10.1.1¹²-д заасны дагуу Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг¹³-т нийцсэн байх ёстой хэдий ч Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр¹⁴ зэрэг бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах, төсөлд санал авах, батлуулах, хэрэгжүүлэх үе шатанд МУХБ хэрхэн оролцож хамтран ажиллах талаар эрх зүйн ямар нэгэн зохицуулалтгүй байна.

- *Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 9.2-т "ЗГХЭГ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, ...УИХ-д өргөн мэдүүлнэ."*
- *Төсвийн тухай хуулийн 28.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэж заасан боловч МУХБ хэрхэн оролцох нь тодорхойгүй;*
- *"Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"¹⁵ -т МУХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр тусгаадаагүй бөгөөд нийт 7,374.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн 11 төсөл, арга хэмжээ нь санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй ангилалд батлагдсан байна.*

1.15 Мөн МУХБ-ны тухай хуулийн /2017 он/ 22.2¹⁶, 23.2¹⁷-д *"УИХ, Засгийн газар МУХБ-ны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй"* гэж заасан байгаагаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18.1-т *"Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна"* гэж заасны дагуу хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг МУХБ-ны санхүүжилтээр төлөвлөн хэрэгжүүлэх боломжгүй байна.

1.16 Бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээ санхүүжилтийн эх үүсвэргүйн улмаас хэрэгжихгүй байх, МУХБ төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй, үндэсний эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн, үр ашигтай, эрчим хүч, металлург, нефть боловсруулах зэрэг хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх, бодит үр дүнд хүргэх боломжийг алдах эрсдэлтэй байна.

⁹МУХБ-ны тухай хуулийн /2017 он/ 10.1.1.МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх;

¹⁰ Төсвийн тухай хууль 28.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна.

¹¹ Төсвийн тухай хууль 28.10 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төсөв, гадаад зээллэг, тусламж болон концессын гэрээ, Засгийн газрын өрийн баталгаа Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээ хамаарна.

¹² 10.1.Хөгжлийн банк дараахь шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ:

10.1.1.Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх;

¹³ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 6.4.Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:

6.4.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;

6.4.2.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;

6.4.3.үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;

6.4.4.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр.

¹⁴ Засгийн газрын 2012 оны 223 дугаар тогтоолоор батлагдсан "МУ-ын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"

¹⁵ Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан "МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"

¹⁶ МУХБ-ны тухай хуулийн /2017 он/ 22.2.Улсын Их Хурал Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төслийн жагсаалтыг тусгайлан батлахгүй.

¹⁷ МУХБ-ны тухай хуулийн /2017 он/ 23.2.Засгийн газар Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй.



МУХБ-ны зорилго, зорилтууд хууль тогтоомжид нийцэж буй хэдий ч 2016 оныг хүртэл уг зорилтыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөгүй ажиллаж байжээ

1.17 МУХБ-ны ТУЗ-ийн 2012 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан 2012-2015 оны бизнес төлөвлөгөөнд хэтийн зорилтыг “Монгол Улсаа олон улсын түвшинд хүрсэн өрсөлдөх чадвар бүхий хөгжингүй, хүчтэй эдийн засаг бүхий улс болгох”, эрхэм зорилгыг “эдийн засгийн өсөлтийг хангасан, улс орны хөгжлийн бодлогыг нэгтгэн хэрэгжүүлж санхүүгийн шинэ шийдлүүдийг нэвтрүүлсэн, эдийн засгийг олон салбарт төрөлжүүлэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэгч тэргүүний банк байна” гэж тодорхойлжээ.

1.18 Хэтийн зорилт, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах 5 зорилтыг тодорхойлсон боловч уг зорилтыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоогүй, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлаагүй байна. Үүнд:

- Тэргүүлэх салбар /эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулах шугам, боловсруулах үйлдвэрлэл, дэд бүтэц/-ын хөгжлийн хөтөлбөр, төслийг дэмжих зорилгоор
 - Дунд болон урт хугацааны зээл олгох;
 - Хамтарсан санхүүжилт, хам зээл болон бусад санхүүгийн шийдлүүдийг нэвтрүүлэх;
- Дотоодын зах зээлд хөрөнгө төвлөрүүлэх, гаднын хөрөнгийн дотогшлох урсгалыг дэмжих;
- Экспортын бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын шинэ салбарыг дэмжих, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх зэргээр эдийн засгийн бүтцийг оновчтой хэлбэрээр төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Бүс нутгийн хөгжлийг дэмжих, хот хөдөөгийн ялгааг багасгах, ажлын байр нэмэгдүүлэх, сайн засаглалын зарчмыг нэвтрүүлэх зэргээр нийгмийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах;
- Олон улсад нэр хүнд бүхий санхүүгийн салбарын бусад байгууллагуудтай хамтран ажиллах.

1.19 МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн банкны дунд болон урт хугацаанд баримтлах стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан 5 зорилго, 20 дэд зорилтын хүрээнд нийт 208 арга хэмжээг 2015-2024 онд зохион байгуулахаар төлөвлөж, жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусгаж иржээ.

- Банкны удирдлагын тогтолцоог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг зарчмуудад бүрэн нийцүүлнэ;
- Улс орныхоо өмнө болон харилцагч байгууллага, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар тогтмол биелүүлнэ,
- Санхүүгийн шилдэг шийдлийг санаачлан хэрэгжүүлж, шуурхай, мэргэжлийн үйлчилгээг тасралтгүй хүргэнэ;
- Урт хугацаанд үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадавхыг бүрдүүлнэ,
- УИХ, Засгийн газраас баталсан эдийн засгийг төрөлжүүлэх, нэмүү өртөг бүтээх, экспортыг урамшуулж, импортыг орлоход чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг үр ашигтай санхүүжүүлэх замаар эдийн засгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг дэмжинэ.

1.20 МУХБ-ны тухай хуулийн шинэчилсэн найруулга, банкны шинэчилсэн дүрэм 2017 оноос мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан МУХБ-ны ТУЗ-ийн 2017 оны 99 дүгээр тогтоолоор банкны 2018-2022 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг 4 зорилго, 27 зорилтын хүрээнд 179 арга хэмжээ зохион байгуулахаар шинэчлэн баталсан байна.

- Бодлогын банк байх - Үр ашигтай, таатай нөхцөл бүхий эх үүсвэр бүрдүүлж, стратегийн ач холбогдолтой салбаруудын төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ;
- Тогтвортой байх - Дунд, урт хугацаанд тогтвортой, үр ашигтай үйл ажиллагаа явуулж байгууллагын чадавхыг сайжруулна;
- Хариуцлагатай байх - Улс эх орныхоо болон олон улсын хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь нэр төртэй биелүүлнэ;
- Мэргэжлийн байх - Банкны байр суурийг бэхжүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллага байна.

1.21 Банкны дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтууд нь “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль”, “Монгол Улсын хөгжлийн банкны дүрэм”, “Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр” зэрэг хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдтэй нийцэж байна.



Банкны захиргааны нэгжийн орон тоо банкны үйл ажиллагаатай бүрэн уялдаагүй байна

1.22 МУХБ-ны ТУЗ нь МУХБ-ны тухай хуулийн /2011 он/ 4.2¹⁸, 22.1¹⁹, Засгийн газрын 2011 оны 151 дүгээр тогтоолыг зөрчин 2015 оны 25 дугаар тогтоолоор банкны бүтцэд Хөрөнгө оруулалтын газрыг шинээр байгуулж, 2016 оны 69, 90 дүгээр тогтоолуудаар татан буулгасан, Гүйцэтгэх захирлын ажлын албыг байгуулсан зэргээр эрх хэмжээгээ хэтрүүлж байжээ.

1.23 Чиг үүргээр батлагдаагүй боловч хуульд заасан болон Засгийн газраас батлагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан Гүйцэтгэх захирлын ажлын албанд дараах чиг үүргийг тус тус хариуцуулжээ. Үүнд:

- Төслийн үнэлгээ, шинжилгээ хийж санхүүжилтийн хэлцлийн санал тодорхойлох;
- Муу зээлийн асуудлыг судлан, хариуцаж ажиллах, эрсдэлийг удирдах;
- Гадаад худалдааны санхүүжилтийн хүрээнд экспортын даатгалын үйлчилгээ үзүүлэх;
- Тоног төхөөрөмжийн лизингийн санхүүжилт хийх.

1.24 Тус ажлын албаны холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Ди Би Эм Ассет менежмент” (үйл ажиллагаа явуулж эхлээгүй), “Ди Би Эм Лизинг” (27 орон тоотой) охин компаниудыг МУХБ-ны тухай, Компанийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 407, 2017 оны 135 дугаар тогтоолуудад үндэслэн, МУХБ-ны ТУЗ-ийн 2017 оны 42, 66 дугаар тогтоолоор байгуулсан байна.

1.25 “Ди Би Эм Лизинг” ХХК 2017 оны жилийн эцсийн байдлаар 346.3 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай, 24 орон тоотой үйл ажиллагаа явуулж байгаа боловч 2017 онд дараах 2 төслийн хүрээнд лизингээр олгосон нийт 34.1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн барьцаа хангалтгүй, даатгалд иж бүрэн хамрагдаагүй, үр ашиг муутай байгаа тул уг чиг үүргийг МУХБ-ны зээлийн хэлтэст хариуцуулах замаар удирдлагын болон үйл ажиллагааны зардлыг хэмнэх нь зүйтэй байна.

- ХХААХҮЯ - Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэн, улаан буудайн үйлдвэрлэлийг дэмжих төсөлд 24.4 тэрбум төгрөг,
- “Баруун баян транс” ХХК - Техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн экспортыг дэмжих төсөлд 9.7 тэрбум төгрөг

Дүрслэл 2. “Ди Би Эм Лизинг” ХХК-ийн үндсэн үзүүлэлт



1.26 МУХБ-ны тухай хуулийн /2011 он/ 18.1.9-д “Хөгжлийн банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасан ч МУХБ-ны ТУЗ-өөс 2016 оныг хүртэлх хугацаанд энэ талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

1.27 МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2017 оны А/311 дүгээр тушаалаар банкны газар, дотоод нэгжийн чиг үүргийн хуваарийг баталсан бөгөөд зарим газар нэгжийн хувьд чиг үүргийн давхардалтай байсныг аудитын явцад залруулсан болно.

1.28 МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2018 оны А/80 дугаар тушаалаар батлагдсан газар, нэгжийн чиг үүргийн хуваариас үзэхэд Гүйцэтгэх захирлын дэргэдэх зарим албадын дараах чиг үүргийг бусад газар, нэгжийн чиг үүрэгтэй нэгтгэн хариуцуулах замаар чиг үүргийн хуваарилалтыг сайжруулах боломжтой байна. Үүнд:

¹⁸ МУХБ-ны тухай хууль /2011 он/ 4.2.Хөгжлийн банкныг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргаж, Улсын Их Хуралд танилцуулна.

¹⁹ МУХБ-ны тухай хууль /2011 он/ 22.1.Засгийн газар Хөгжлийн банкны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 22.1.2.Хөгжлийн банканд бүтцийн өөрчлөлт хийх, өөрчлөн байгуулах;



Гүйцэтгэх захирлын ажлын алба:

- “Банкны үндсэн үйл ажиллагааг төрийн бодлоготой уялдуулах ажлыг зохион байгуулах” чиг үүргийг ХШТГ-ын “Банкны үйл ажиллагааны хууль тогтоомжийн нийцлийг хангах, үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад хууль зүйн хүрээнд дэмжлэг үзүүлэх” чиг үүрэгтэй нэгтгэн хариуцуулах;
- “Уулзалт, хурал, конференц, ярилцлагад оролцсон тэмдэглэлийн бүртгэлийг хөтлөх, үүнтэй холбоотой мэдээллийн цахим сан бүрдүүлэх”, “Захирлуудын зөвлөлийн хурал болон банкны удирдлагын шуурхай хурлын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, шийдвэрийн биелэлтийг нэгтгэх” чиг үүргүүдийг ХШТГ-ын Тамгын хэлтсийн “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг эрхлэх...”, “архивын сан хөмрөгийг бүрдүүлэх ...”, “банкны бүх ажилтны болон ХШТГ-ын хурлыг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөх, үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэж удирдлагад танилцуулах” чиг үүрэгтэй нэгтгэн хариуцуулах;
- “Нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий төслүүдийг тодорхойлон санаачлах, түүнийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах” чиг үүрэг ТСЗГ-ын Төслийн зээл, санхүүжилтийн хэлтсийн “банкны зорилгод нийцсэн шинэ төсөл, хөтөлбөрүүд, боломжит бүтээгдэхүүний судалгаа хийж, санал боловсруулах” чиг үүрэгтэй нэгтгэн хариуцуулах боломжтой байна.

1.29 Мөн тус банкны Хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн чиг үүрэгт “хөрөнгө оруулалтын багцыг үр ашигтай удирдах, хөрөнгө оруулсан ААН-д хувьцаа эзэмшигчийн эрх болон тэдгээрийн ТУЗ дахь Банкны төлөөллийг хэрэгжүүлэх” гэж заасан хэдий ч уг чиг үүргийг аль нэгж хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

1.30 Санхүүгийн шилдэг шийдлийг санаачлан хэрэгжүүлэх, мэргэжлийн үйлчилгээг шуурхай, тасралтгүй хүргэх зорилтын хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх, экспорт, импортын санхүүжилт хийх үйл ажиллагаа газар, хэлтсүүдийн ажил үүргийн хуваарьт тусгагдаагүй, энэ чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна.

1.31 МУХБ-ны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлснээр МУХБ-ны ТУЗ нь банкны бүтцийг батлах зохицуулалттай болсон бөгөөд 2017 оны 91 дүгээр тогтоолоор банкны зохион байгуулалтын бүтцийг нийт 4 газар, 3 алба, 13 хэлтэс бүхий 157 орон тоотой байхаар баталжээ.

Хүснэгт 1. Банкны газар, хэлтэс, албадын орон тооны харьцуулалт /хүний тоо/


Газар, хэлтэс, алба	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	Нэмэгдсэн орон тоо
1	2	3	4	5	6	7	5=7-6
Дотоод аудитын алба, ТУЗ-ийн ажлын алба	2	2	4	4	6	7	1
Гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, газрын захирал	6	6	6	6	6	6	-
Гүйцэтгэх захирлын дэргэдэх албад	-	-	-	-	12	14	2
Төслийн санхүүжилт, зээлийн газар	21	21	53	53	29	29	0
Актив, пассив хөрөнгийн удирдлагын газар	21	21	26	26	22	25	3
Эрсдэлийн үнэлгээ, удирдлагын газар	9	9	15	15	13	16	3
Хяналт, шалгалт тамгын газар	19	24	37	37	52	60	8
Хөрөнгө оруулалтын газар	-	-	18	18	-	-	-
Нийт	78	83	159	159	140	157	17

Эх сурвалж: МУХБ-ны ТУЗ-ийн тогтоолууд

1.32 Банкны үндсэн үйл ажиллагаа хумигдаж нийт татан төвлөрүүлэх хөрөнгө болон зээл олголт буурсаар байхад бүтэц, орон тоо багасаагүй, харин дэмжих чиг үүргийг хэрэгжүүлдэг Хяналт, шалгалт тамгын газар, Гүйцэтгэх захирлын дэргэдэх албадын орон тоог өмнөх онтой харьцуулахад 2016 онд 27, 2017 онд 10 орон тоогоор тус тус нэмэгдэж, тэдгээрт зарцуулсан боловсон хүчний зардал 2017 онд өмнөх онуудын дунджаас 9.2 орчим хувиар буюу 504.2 сая төгрөгөөр нэмэгджээ.



Дүрслэл 3. МУХБ-ны 2012-2017 оны орон тооны харьцуулалт /тэрбум төгрөг/



1.33 Дүрслэлээс харахад захиргааны чиг үүрэг бүхий нэгжийн орон тоо ажлын байрны зураг авалт, ажлын ачаалалд бүрэн үндэслээгүй, орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бодитой бус, банкны үйл ажиллагааны цар хүрээ хумигдсантай холбоотойгоор МУХБ-ны үндсэн бүтэц, зохион байгуулалтыг үр ашигтай байдлаар шинэчлэн зохион байгуулах замаар үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

Арвилан хэмнэлттэй ажиллах зарчмыг хангаагүй, үр ашиггүй зарцуулалт хийж иржээ

1.34 МУХБ-ны ТУЗ нь банкны үйл ажиллагаа, үндсэн хөрөнгө бэлтгэх зардлаас гадна бонд гаргах эх үүсвэрийн зардал, гүйцэтгэх удирдлагын гадаад албан томилолт зэрэг арга хэмжээний зардлыг тухай бүрд нь баталж ирсэн бөгөөд 2012-2017 оны зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. МУХБ-ны зардлын гүйцэтгэл /сая төгрөг/


Зардлын зүйл	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Цалин хөлс, тэтгэмж	1,010.3	2,383.7	4,256.3	5,267.5	5,061.8	5,970.8
Бусад зардал	291.7	981.1	1,424.9	1,944.5	1,581.1	1,805.4
Хууль зүй, аудит, мэргэжлийн үйлчилгээ	243.5	232.0	739.0	3,721.2	3,187.5	1,221.6
Элэгдэл, хорогдол	149.9	204.0	274.8	355.9	826.5	1,113.7
Олон нийтэд мэдээлэл хүргэх зардал	7.9	793.1	1,249.0	720.7	1,250.9	586.4
Нийт	1,695.4	3,800.8	6,695.1	11,289.1	10,657.0	10,111.5

Эх сурвалж: МУХБ-ны 2012-2017 оны аудитлагдсан санхүүгийн тайлан

1.35 Удирдлагын болон үйл ажиллагааны зардлын дүнд ажиллагсадтай холбоотой зардал 46.7-63.6 хувь, хууль зүй, санхүүгийн мэргэжлийн үйлчилгээний зардал 6.1-33.0 хувь, олон нийтэд мэдээлэл хүргэх зардал 0.5-18.7 хувь, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 3.2-11.0 хувь, бусад зардал 14.8-21.3 хувийг тус тус эзэлж байна.



Дүрслэл 4. МУХБ-ны 2012-2017 оны зардлын гүйцэтгэл /сая төгрөг/



1.36 Боловсон хүчинтэй холбоотой зардал 2016 оноос бусад онуудад өмнөх оноос 18-178.6 хувиар тус тус өсөхөд орон тоо 6.4-91.6 хувиар нэмэгдсэн, ТУЗ-ийн 2013 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажилтны үр чадвар, ажлын гүйцэтгэлийг дүгнэж, урамшуулал олгох журам”-ын дагуу 488.5-1,161.3 сая төгрөгийн нэмэгдэл цалин олгосон нь голлон нөлөөлсөн байх тул орон тоо, ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх журмыг хянан үзэж, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримталж ажиллах шаардлагатай байна.

1.37 Гадаад албан томилолтын зардлыг МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2013 оны А-127 дугаар тушаалаар батлагдсан “Албан томилолтын журам”-д заасан зочид буудал, зам хоногийн зардлын хэмжээг баримтлаагүй, арвилан хэмнэлтгүй зарцуулж байжээ. Тухайлбал,

- ТУЗ-ийн 2013 оны 68 дугаар тогтоолын дагуу Гүйцэтгэх захирал Н.Мөнхбатын БНХАУ-д хийсэн албан томилолтын зочид буудлын төлбөрт 7.0 сая төгрөг, нислэгийн тийз болон бусад зардал нийт 2.6 сая төгрөг;
- ТУЗ-ийн 2014 оны 30 дугаар тогтоолын дагуу Гүйцэтгэх захирал Н.Мөнхбатын ОХУ-ын Санкт-Петербург хотод хийсэн албан томилолтын 3 хоногийн зочид буудлын төлбөрт 12.2 сая төгрөг, нислэгийн тийз болон бусад зардал зэрэгт нийт 8.2 сая төгрөг зарцуулсан байна.

1.38 Банкны үйл ажиллагаа, санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаар үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор телевиз, сонин хэвлэл, мэдээллийн сайт, олон нийтийн сүлжээний идэвхжүүлэлтэд 2013 онд 793.1 сая төгрөг, 2014 онд 1,249.0 сая төгрөг, 2015 онд 720.6 сая төгрөг, 2016 онд 1,250.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байх бөгөөд тухайн үед банкны үйл ажиллагааг идэвхтэй сурталчлах зайлшгүй хэрэгцээ шаардлага байсан гэж үзэх боломжгүй байна.

1.39 МУХБ нь Засгийн газар, Сангийн яамнаас өгсөн зарим үүрэг, чиглэлийн дагуу банкны үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй, ач холбогдол багатай арга хэмжээнд 873.9 сая төгрөг зарцуулсан нь үр ашиггүй зарцуулалт болсон төдийгүй, МУХБ-ны тухай хуульд заасан “хараат бус байх” зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүйг харуулж байна. Тухайлбал,

- Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 58 дугаар тэмдэглэлээр ЗГҮЦ-ыг арилжаалан бүрдүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, нийгэм эдийн засгийн үр өгөөжийг олон нийтэд мэдээлэх, танилцуулах зорилгоор “Чингис бонд үндэсний үйлдвэрлэл үзэсгэлэн, худалдаа” арга хэмжээг нийслэлд 2016 оны II улиралд зохион байгуулахыг МУХБ-нд даалгасны дагуу үзэсгэлэн, сэтгүүл, заалны түрээс, пи-ар, видео шторк зэрэгт 519.7 сая төгрөгийг зарцуулсан;
- Сангийн сайдын 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 8-1/2656 дугаар албан бичгээр “МУХБ-ны 2012-2016 оны үйл ажиллагаанд дэлгэрэнгүй шинжилгээ хийлгэж, тусгай дүгнэлт гаргуулан үр дүнг Засгийн газарт танилцуулах” чиглэлийн дагуу худалдан авах ажиллагааны журмын 6.1.6²⁰, МУХБ-ны Дотоод аудитын дэд хорооны санал, МУХБ-ны ХШТГ-ын танилцуулгыг үндэслэн МУХБ-ны ТУЗ-ийн 2017 оны 5

²⁰ МУХБ-ны хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах журам 6.1.6. Хувьцаа эзэмшигчээс өгсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэх зорилгоор ажил, үйлчилгээг нээлттэй эсхүл хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол.



дугаар сарын 19-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор шууд гэрээний аргаар “Делoitт Онч аудит” ХХК-тай нийт 354.2 сая төгрөгийн үнэ бүхий “Үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр байгуулан тайланг 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авчээ.

1.40 МУХБ-нд 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 10 автомашин ашиглагдаж байгаагаас 8 нь газрын захирлуудын хэрэгцээнд хот дотор ашиглаж буй шатахуун зарцуулалт өндөртэй²¹ Nissan Navara, Toyota LC Prado 150, LC 200 маркийн том оврын жийп бөгөөд 2016-2017 оны томилолтын баримтаас үзэхэд жилд 5 буюу түүнээс дээш удаа орон нутагт томилолтоор явсан 4 автомашин байгаа нь том оврын жийп машины хэрэгцээ шаардлага бага байгааг харуулж байна.

1.41 МУХБ-ны Гүйцэтгэх удирдлага 2015-2017 онд 5 ажилтныг ажлаас үндэслэлгүйгээр чөлөөлсний улмаас шүүхийн шийдвэрийн дагуу буцаан томилогдсон тэдгээр ажилтанд ажиллаагүй хугацааны цалин, НДШ, тэмдэгтийн хураамж зэрэгт нийт 89.5 сая төгрөгийг зарцуулж, үргүй зардал гаргажээ.

1.42 Энэ зардлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгуулах, хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргаж байх, үндэслэлгүй шийдвэр гаргаж байгууллагад хохирол учруулсан албан тушаалтанд хариуцлага тооцдог тогтолцоог дүрэм, журамдаа Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн нарийвчлан тусгаж мөрдүүлэх нь зүйтэй байна.

Худалдан авах ажиллагаанд мөрдөж буй журмын зохицуулалт хангалтгүй байгаа нь арвилан хэмнэлтгүй худалдан авалт хийгдэх нөхцөлийг бүрдүүлж байх тул ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөх нь зүйтэй байна

1.43 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.6-д “МУХБ-ны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заасантай холбогдуулан МУХБ-ны гүйцэтгэх захирлын тушаалаар банкны хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмыг баталж, түүнд дараах байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулж иржээ.

- МУХБ-ны хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмыг Гүйцэтгэх захирлын 2013 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/127 дугаар тушаал, 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/106 дугаар тушаал, 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А/100 дугаар тушаалаар тус тус шинэчлэн баталсан,
- Гүйцэтгэх захирлын 2016 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А-40 дүгээр тушаалаар холбогдох журамд “Хувьцаа эзэмшигчээс өгсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэх зорилгоор ажил, үйлчилгээг нээлттэй, эсхүл хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол” шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэх заалтыг нэмсэн.

1.44 Тус журам нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахад үүсэх харилцааг бүрэн зохицуулаагүй, сонгон шалгаруулалт явуулахтай холбогдсон нөхцөл байдлыг бүрэн тодорхойлоогүй байна. Тухайлбал,

- Хязгаарлагдмал сонгон шалгаруулалтын аргыг хэрэглэх талаар тусгаагүй;
- Харьцуулалтын аргыг хэн, хэрхэн хэрэглэх талаар зохицуулсан зохицуулалт байхгүй;
- Худалдан авах гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийн талаар тусгаагүй;
- Нээлттэй сонгон шалгаруулалтын тендерийн баримт бичгийг ажлын хэсэг, тухайн ажил хариуцсан нэгж, ажилтны аль нь боловсруулах нь тодорхойгүй;
- Тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулах зохицуулалт тусгаадаагүй;
- Шаардлагад нийцсэн бүх сонгон шалгаруулалтын үнэ батлагдсан төсвөөс хэдэн хувь хэтэрсэн тохиолдолд бүх сонгон шалгаруулалтын материалаас татгалзах нь тодорхойгүй;
- Худалдан авах ажиллагаанд Дотоод хяналт, шалгалтын нэгжийн хяналт хэрхэн хэрэгжих талаар тодорхойлсон зохицуулалтгүй;
- Шууд болон харьцуулалтын аргаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гэрээнд урьдчилгаа төлбөрийг хэрхэн олгох талаар зохицуулалт байхгүйгээс дийлэнх гэрээнүүд гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 хоногийн дотор гэрээний үнийн дүнгийн 70 хувийн урьдчилгаа төлбөр төлөх, захиалагчид актаар хүлээлэн өгсний дараа үлдэгдэл төлбөр 30 хувийг төлөх нөхцөлтэй хийгдэж байгаа нь санхүүжилттэй уялдуулан гэрээний хэрэгжилтийг хангуулах боломжгүй болох эрсдэлтэй байна.

1.45 МУХБ-ны захиргаа, санхүү, аж ахуйн дотоод хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахдаа гүйцэтгэх захирлын баталсан журмыг мөрдөж

²¹ Улирлаас шалтгаалан 100 км-т дунджаар 19-21.5 л шатахуун зарцуулдаг



байгаа нь учир дутагдалтай байх бөгөөд дээрх ажил, үйлчилгээг худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөхгүй байх зайлшгүй үндэслэл, шаардлага харагдахгүй байна.

1.46 МУХБ-ны Гүйцэтгэх удирдлага нь банкны хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд мөрдөх журмыг өөрөө бие даан баталж, мөрдүүлж байгаа нь төрийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалт ил тод бус, арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй байдлаар хэрэгжих эрсдэлтэй байна.

1.47 Тухайлбал, 2015 онд 27,976.0 сая төгрөгийн, 2016 онд 516.1 сая төгрөгийн, 2017 онд 580.2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авснаас 70-90 орчим хувьд шууд гэрээ байгуулах, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах замаар гүйцэтгэгчийг сонгожээ.

- 2015 онд МУХБ-ны үйл ажиллагаа, санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор нийт 215.1 сая төгрөгийн үнэ бүхий ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг шууд болон харьцуулалтын аргаар шалгаруулж 12.0-49.0 сая төгрөгийн 6 гэрээ байгуулсан,
- 2017 онд нийт 164.6 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн болон суурин компьютер, сервер компьютер нийлүүлэгчийг шууд болон харьцуулалтын аргаар шалгаруулж 3.5-42.5 сая төгрөгийн 8 гэрээ байгуулсан.

1.48 МУХБ-ны ТУЗ нь 2015 онд гүйцэтгэх удирдлагаас баталсан, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан “МУХБ-ны хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах журам”-ын 3.1.1²², 5.1.5²³, 43.2²⁴, 43.2.1²⁵ дэх заалтуудыг зөрчин тендер шалгаруулалтыг зохион байгуулалгүйгээр 3,240.0м² талбай бүхий ажлын байрны зориулалттай үл хөдлөх хөрөнгө, 10 ширхэг авто зогсоолыг 27.6 тэрбум төгрөгөөр шууд худалдан авах шийдвэрийг гаргажээ.

1.49 Худалдан авах ажиллагааны шийдвэрийг гаргасан тухай үеийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь эрх зүйн чадамжтай гэж үзэхэд учир дутагдалтай байна.

- Засгийн газрын 2012 оны 83 дугаар тогтоолоор ЭЗХЯ-ны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Шинэбаатарыг МУХБ-ны ТУЗ-ийн даргаар томилсон боловч УИХ-ын 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар ЭЗХЯ татан буугдсан тул Б.Шинэбаатар нь уг албан тушаалаас чөлөөлөгдсөн байна.
- Засгийн газрын 2015 оны 30 дугаар тогтоолоор МУХБ-ны ТУЗ-ийн гишүүнээр Уул уурхайн яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга байхаар томилсон бөгөөд уг албан тушаалд ажиллаж байсан Ч.Отгочулууг Уул уурхайн яамны ТНБД-ын 2015 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 29 дүгээр тушаалаар үүрэгт ажлаас нь чөлөөлсөн тул ТУЗ-ийн гишүүнээр ажиллах боломжгүй байжээ. Гэтэл МУХБ-ны ТУЗ-ийн хурлаар уг үл хөдлөх хөрөнгийг худалдан авах асуудлыг 2015 оны 6 дугаар сарын 16, 18-ны өдрүүдэд хэлэлцэх үед гишүүдийн ирц бүрдэхгүй байна гэдэг шалтгаанаар Ч.Отгочулууг уг хуралд оролцуулжээ.
- МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар уг асуудлыг хэлэлцэж гишүүд судлах шаардлагатай гэж үзсэн тул дахин хэлэлцэхээр хойшлуулсан байна. 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар “үндсэн хөрөнгө худалдан авч, гэрээ байгуулах эрх олгох” тухай шийдвэрлэсэн хэдий ч ТУЗ-ийн тогтоол 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөр баталгаажсан, ТУЗ-ийн хурлын тэмдэглэлүүд гарын үсгээр баталгаажгаагүй байна.

1.50 Аудитын явцад хөндлөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний байгууллагаар МУХБ-ны 2015 онд худалдан авсан барилгад зах зээлийн бодит үнэ ханшийн үнэлгээ хийлгэхэд “худалдан авалт хийх үеийн буюу 2015 оны 7 дугаар сарын байдлаар зах зээлийн бодит үнэлгээ 17.4 тэрбум төгрөг, 2018 оны 4 дүгээр сарын байдлаар зах зээлийн бодит үнэлгээ 14.9 тэрбум орчим төгрөг байна” гэж дүгнэлт²⁶ гаргасан.

²² МУХБ-ны хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах журам. 3.1.1 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг ил тод, хэмнэлттэй, үр ашигтай явуулах,

²³ МУХБ-ны хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах журам 5.1.5 50,000,001 төгрөгөөс дээш өртөгтэй бараа, үйлчилгээ, 80,000,001 төгрөгөөс дээш өртөгтэй ажил худалдан авахдаа тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгох ба гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг ТУЗ гаргана.

²⁴ МУХБ-ны хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах журам 43.2 Банк энэ хуулийн 43.1-д заасны дагуу зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа дараах мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлнэ;

²⁵ МУХБ-ны хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах журам 43.2.1 Худалдан авах ажиллагааг зарлан мэдээлэхийн өмнө тендерийн баримт бичгийн төсөл;

²⁶ Хөндлөнгийн, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний байгууллагын “Хөрөнгийн үнэлгээний тайлан” 2018.04.10



Зураг 1. МУХБ-ны ажлын байртай ижил төстэй үл хөдлөх хөрөнгийн өртөг, үнийн харьцуулалт



Ойролцоо байршил бүхий МУИС-ийн номын сангийн 15,092м² талбай бүхий зоорьтой 6 давхар барилга 2015-2016 онд 19.8 тэрбум төгрөгөөр баригдсан



Ажлын байрны зориулалттай 3,240.0м² талбай бүхий 2 давхар үл хөдлөх хөрөнгө, 10 ширхэг авто зогсоолыг 2015 онд 27.6 тэрбум төгрөгөөр худалдан авсан

1.51 Мөн МУХБ-ны худалдан авсан ажлын байртай ойролцоо байршилд 15,092м² талбай бүхий 6 давхар барилга 2015-2016 онд нийт 19.8 тэрбум төгрөгөөр баригдсан нь дээрх хөндлөнгийн үнэлгээг бодитой гэж үзэх үндэслэлтэйг харуулж байна.

1.52 Хууль, эрх зүйн чадамжтай эсэх нь эргэлзээтэй ТУЗ-ийг болон түүний МУХБ-нд 10.2 тэрбум орчим төгрөгийн хохирол учруулсан байж болзошгүй үндсэн хөрөнгө худалдан авахад гаргасан шийдвэрийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж, учирсан хохирлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. МУХБ 2012-2016 ОНУУДАД ТООЦОО СУДАЛГААГҮЙГЭЭР ЭХ ҮҮСВЭР ТАТАЖ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГЫГ ЗОХИСГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭС ИХ ХЭМЖЭЭНИЙ АЛДАГДАЛ ХҮЛЭЭСЭН БАЙНА

Оршил

Энэ бүлэгт МУХБ-ны эх үүсвэр татан төвлөрүүлэлт, мөнгөн хөрөнгийн удирдлагын асуудлыг “Үйл ажиллагааны хамрах хүрээнд үндсэн зорилго, ашигт ажиллагаанд нийцсэн, хямд өртөгтэй эх үүсвэр татан төвлөрүүлсэн эсэх”, “Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үр ашигтай, эрсдэлгүй удирдсан эсэх” зорилтын хүрээнд МУХБ-ны 2012-2017 оны хугацаанд татан төвлөрүүлсэн эх үүсвэр, тэдгээрийн удирдлагыг авч үзэв.

Аудитын хамарсан хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгө дараах байдалтай байна. Үүнд:

Евро бонд:

Засгийн газрын 2011 оны 85 дугаар тогтоолыг үндэслэн Засгийн газрын баталгаатайгаар 2011 оны 11 дүгээр сард 600.0 сая ам.долларын евро бондыг гаргаж 1 жилийн хугацаатай, 6 хувийн хүүтэй 20.0 сая ам.долларыг 2011 оны 12 дугаар сард, 2012 оны 03 дугаар сард 5 жилийн хугацаатай, 5.75 хувийн хүүтэй 580.0 сая ам.долларыг төвлөрүүлсэн байна.

МУХБ-ны Монголбанк дахь ам.долларын харилцах дансанд холбогдох шимтгэлийг суутгасан дүн болох 19.8 сая ам.доллар 2011 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, 578.4 сая ам.доллар 2012 оны 03 дугаар сарын 21-ний өдөр тус тус шилжин орсон байна.

Хүснэгт 3. Евро бондын зарцуулалт /сая ам.доллар, тэрбум төгрөг, хувь/

№	Эх үүсвэр		Зарцуулалт	Валют	Санхүүжүүлсэн	Хүү, хувиар
	Дүн /сая ам.доллар/	Хүү, хувиар			дүн /сая ам.доллар/	
1	580.0	5.75	“Эрдэнэс таван толгой” ХК	USD	200.0	7.35-7.38
2			Авто зам, гудамж төсөл	USD	95.9	7.34
3			Эрчим хүч	USD	82.4	7.34-7.38
4			Шинэ төмөр зам	USD	22.5	7.38
5			Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор	MNT	0.6	7.38
6			ЖДҮХСАН- 888 ТӨСӨЛ-2014	MNT	75.2	5.0
7			Бусад	MNT	36.1	7.38-16.0
				USD	6.9	7.34-8.0

Эх сурвалж: МУХБ

Чингис бонд:

УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолоор эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлого арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны 5.0 тэрбум ам.доллар хүртэлх Засгийн газрын үнэт цаасыг 2012-2014 онуудад үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн ба уг хөрөнгийг нийгмийн халамжийн аливаа үйлчилгээ болон улсын төсвийн орлогын дутагдлыг нөхөхөөс бусад эрдэс баялаг, зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, барилга, банк санхүү, аж үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх эдийн засгийн үр ашиг бүхий томоохон төслүүдэд хөрөнгө оруулахад зарцуулахыг Засгийн газарт даалгасан байна.

Энэ хүрээнд нийт 1.5 тэрбум ам.долларын бондыг дараах үндсэн нөхцөлтэйгөөр авчээ.

Хүснэгт 4. Чингис бондын нөхцөл /сая ам.доллар, хувь/

Бондын дүн	500.0 сая ам.доллар	1,000.0 сая ам.доллар
Бондын хүү жилийн	4.125 хувь	5.125 хувь
Бондын хугацаа	5 жил	10 жил
Гэрээ байгуулсан огноо	2012.11.28	2012.11.28

Эх сурвалж: МУХБ

Сангийн яамны дансанд Чингис бондын 1.5 тэрбум ам.долларыг 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хүлээж авснаас 5 сарын дараа Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Хөгжлийн банк



харилцан тохиролцож 2013 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 01/12/3/88 дугаар “Санхүүгийн зуучлалын гэрээ”-г байгуулсан байна.

Уг гэрээнд санхүүгийн зуучлалын хүрээнд хөрөнгө эзэмшигч талууд 1.5 тэрбум хүртэлх ам.доллар болон түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн эх үүсвэрийг жилийн 4.7917 хувийн хүүтэйгээр тухай бүрд Хөгжлийн банканд байршуулахаар заасны дагуу Хөгжлийн банкны Монголбанк дахь дансанд 2,021.25 тэрбум төгрөг, 269.9 ам.долларыг нийт 10 удаагийн гүйлгээгээр шилжүүлсэн байна.

Хүснэгт 5. Чингис бондын зарцуулалт /сая ам.доллар, тэрбум иен, тэрбум төгрөг, хувь/

№	Эх үүсвэр		Зарцуулалт	Валют	Санхүүжүүлсэн дүн /сая ам.доллар/	Хүү, хувиар
	Дүн	Хүү, хувиар /СЯ-тай байгуулсан гэрээгээр/				
1	2,021.2 тэрбум төгрөг, 269.9 сая ам.доллар	4,7917	Авто зам, гудамж төсөл	USD	4.4	6.125
2			Эрчим хүч	MNT	808.7	4.7917-6.125
3				MNT	366.6	
4				MNT	136.8	
5			ТОСК ТӨҮГ	MNT	99.2	7.0
6			Шинэ төмөр зам	USD	197.2	6.125
7			ХАА-н 5 салбарыг дэмжих хөтөлбөр	MNT	214.4	5.125
8			Ноолуур хөтөлбөр	MNT	46.8	6.0
9			Монполимет ХХК	USD	65.0	5.125-8.0
10			Мак цемент ХХК	USD	20.05	7.79-8.79
			Бусад	MNT	60.7	4.7917-10.0
				USD	62.9	5.125-8.0

Эх сурвалж: МУХБ

Самурай бонд:

Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны ТУЗ-д Японы Олон Улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-ны баталгаатай 30.0 тэрбум иентэй тэнцэх хэмжээний “Самурай” үнэт цаасыг 10 жилийн хугацаатай, гадаад валютаар, хаалттай хэлбэрээр Япон Улсын үнэт цаасны зах зээл дээр гаргахыг зөвшөөрчээ.

Тус бондыг 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр жилийн 1.52 хувийн хүүтэйгээр арилжаалж, үндсэн эх үүсвэр болох 30.0 тэрбум иенээс холбогдох зардлыг суутгуулж 24.3 тэрбум иен 2014 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр Хөгжлийн банкны Монголбанк дахь дансанд орсон байна.

Хүснэгт 6. Самурай бондын зарцуулалт /сая ам.доллар, тэрбум иен, тэрбум төгрөг, хувь/

№	Эх үүсвэр		Зарцуулалт	Валют	Санхүүжүүлсэн дүн /сая ам.доллар/	Хүү, хувиар
	Дүн	Хүү				
1	30.0 тэрбум иен	Нэрлэсэн хүү 1.52%/бодит хүү 4.39%/	6 хувийн орон сууцны зээлийн санхүүжилт	USD	58.4	6.75
2			“Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ	USD	38.7	5.0

Эх сурвалж: МУХБ

Кредит Свисс банкны зээл:

Засгийн газрын 2014 оны 117 дугаар тогтоол, Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2014 оны 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдөр Хөгжлийн банк, Швейцарийн Кредит Свисс банкт арьс ширний үйлдвэр, дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр 300.0 сая ам.долларын зээлийн гэрээ байгуулжээ.

МУХБ зээлийн санхүүжилтийн эхний хэсэг болох 5 жилийн хугацаатай, 6 сарын лайбор +4.375 хувийн хүүтэй 180.4 сая ам.долларыг 2014 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр, үлдэгдэл хэсэг болох 115.0 сая ам.долларыг 3 жилийн хугацаатай, 6 сарын лайбор +4.25 хувийн хүүтэй 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авсан.



Хүснэгт 7. Кредит Свисс банкны зээлийн зарцуулалт, /сая ам.доллар, тэрбум төгрөг, хувь/

№	Эх үүсвэр		Зарцуулалт	Валют	Санхүүжүүлсэн дүн /сая ам.доллар/	Хүү, хувиар
	Дүн /сая ам.доллар/	Хүү				
1	300.0	4.50% + 6М Лайбор /бодит хүү 6.28%/	Авто замын төслүүд	USD	32.5	7.34
2				MNT	82.9	6.13
3			300 тэрбум	MNT	119.8	6.0
4			Арьс шиш хөтөлбөр	MNT	68.8	5.0
5			Газар тариалан хөтөлбөр	MNT	22.2	9.0
6			ЖДҮ – 70 хөтөлбөр	MNT	63.4	6.0
7			888-2,0-с дээш	MNT	150.0	5.0
			Оюутолгой болон бусад стратегийн ач холбогдол бүхий төслийн санхүүжилт	USD	2.5	7.65
8			МИАТ ТӨХК	USD	6.8	6.62
9			“Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ	USD	35.5	7.0

Эх сурвалж: МУХБ

Каргилл санхүүгийн байгууллагын зээл

Засгийн газрын 2016 оны 50 дугаар тогтоол, Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2016 оны 17 дугаар тогтоолоор Каргилл олон улсын санхүүгийн байгууллагатай экспортыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор 75.0 сая ам.долларын зээлийн гэрээг 2016 оны 04 дүгээр сарын 10-нд жилийн 9.5 хувийн хүүтэйгээр хоёр жилийн хугацаатайгаар байгуулжээ.

Гэрээний дагуу 2016 оны 4 дүгээр сарын 22-нд 75.0 сая ам.долларыг Хөгжлийн банк нь Монгол банк дахь дансандаа хүлээн авч 2018 оны 4 дүгээр сард эргэн төлөлтийг хийжээ.

Хүснэгт 8. Каргилл санхүүгийн байгууллагын зээлийн зарцуулалт, /тэрбум төгрөг, сая ам.доллар, хувь/

Түрэмэг 3. Нарийн санхүүгийн байгууллагын өсөлтийн зарцуулалт, төрөлжмөөрс, сая ам.доллар, хувиар						
№	Эх үүсвэр		Зарцуулалт	Валют	Санхүүжүүлсэн дүн /сая ам.доллар/	Хүү хувиар
	Дүн /сая ам.доллар/	Хүү, хувиар				
1	75.0	9.5	Кью Эс Си ХХК	USD	71.3	8.0
2			Шинэ төмөр зам төсөл	USD	4.6	7.37
				MNT	3.7	

Эх сурвалж: МУХБ

БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл:

БНХАУ-ын Хөгжлийн банк, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд БНХАУ-ын оролцоотой төслүүдийг санхүүжүүлэхэд хамтран ажиллах, Чингис бондын эх үүсвэрээс санхүүжүүлсэн зээлийг дахин санхүүжүүлэхэд зориулагдах 8 жилийн хугацаатай, 6 хувийн хүүтэй, 162.0 сая ам.долларын зээлийн гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 9. БНХАУ-ын Хөгжлийн банкны зээлийн зарцуулалт, /сая ам.доллар, хувь/

№	Эх үүсвэр		Зарцуулалт	Валют	Санхүүжүүлсэн дүн, /сая ам.доллар/	Хүү, хувиар
	Дүн /сая ам.доллар/	Хүү, хувиар				
1	162.0	6.0	Амгалан дулааны станц	USD	14.0	7.9
2			ДЦС-3 хүчин чадал нэмэгдүүлэх		72.1	7.38
3			Авто замын төслүүд		75.9	7.34

Эх сурвалж: МУХБ

Бусад эх үүсвэр:

Бусад эх үүсвэрээс 2012-2014 онуудад 29.9 сая ам.доллар, 53.1 сая еврогийн зээлийн шугам нээлгэсэн байна. Үүнд:

1. Засгийн газрын 2012 оны 99, 119 дүгээр тогтоол, 2014 оны 202 дугаар тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 29 дүгээр тогтоолыг үндэслэн “Дулааны 4 дүгээр цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр суурилуулах турбогенератор худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийг дахин санхүүжүүлэх”, хоёр орны бараа, үйлчилгээний экспортыг санхүүжилтийн хэлбэрээр дэмжих, харилцан ашигтай харилцааг хөгжүүлэх зорилготойгоор ОХУ-ын Внешэкономбанкаас 6-8 жилийн хугацаатай, 2.5-7.16 хувийн хүүтэй, 29.9 сая ам.долларын зээл авсан.



2. Засгийн газрын 2014 оны 113 дугаар тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 26 дугаар тогтоолыг үндэслэн “Эрэл” ХХК-ийн “Байшин үйлдвэрлэх комбинат-1” төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор ХБНГУ-ын Коммерц банкт 13.1 сая еврогийн санхүүжилтийн гэрээг байгуулсан байна.

3. Засгийн газрын 2015 оны 93 дугаар тогтоол, МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 30, 98 дугаар тогтоол, 2016 оны 31 дүгээр тогтоолуудыг үндэслэн ОХУ-ын ВТБ банк 7 жилийн хугацаатай, 6 хувь+Euribor 3М хүүтэй, 20.0 сая хүртэлх еврогийн зээлийн шугам нээсэн.

4. Засгийн газрын 2015 оны 319 дүгээр тогтоолыг үндэслэн Олон улсын хөрөнгө оруулалтын банкт 2014 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр хоёр банкны санхүүгийн боломжийг үр дүнтэй ашиглах, харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгон хөгжүүлэх замаар урт хугацаанд хамтрах нөхцөлийг бүрдүүлэх зорилготойгоор “Стратегийн түншлэлийн гэрээ” байгуулан, 7 жилийн хугацаатай, 6 хувь+Euribor 3М хүүтэй, 20.0 сая хүртэлх еврогийн зээлийн шугам нээсэн.

5. Засгийн газрын 2015 оны 344 дүгээр тогтоолыг үндэслэн АСЕМ буюу Ази, Европын дээд түвшний 11 дэх уулзалтын бэлтгэл ажилд шаардагдах санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор нийт 233.4 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас гаргасан байна.



Бэлтгэл ажлыг бүрэн хангахгүйгээр бонд гаргасан, зарим бондын эх үүсвэр татах үйл ажиллагааны зардал өндөр байгаа нь бодит хүү нэмэгдэхэд хүргэсэн байна

2.1 МУХБ татан төвлөрүүлэх эх үүсвэрийн хэмжээг дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөнд тусган төлөвлөж байсан хэдий ч санхүүжүүлэх төслүүдийн эдийн засгийн үр ашгийн тооцоо, ТЭЗҮ, зураг төсөл зэрэг төлөвлөлт, судалгааны бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй ерөнхий нэрсийн жагсаалт батлагдсан байжээ. Тухайлбал,

- ТУЗ-ийн 2012 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан 2012-2015 оны бизнес төлөвлөгөөнд 2012-2015 онуудад 1,001.0-1,589.0 тэрбум төгрөг нийт 5,585.8 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж, 1,014.8-1,582.0 тэрбум төгрөгийн төслийн орлогоос эргэн төлөгдөх зээл олгохоор;
- ТУЗ-ийн 2015 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан дунд болон урт хугацаанд баримтлах стратегийн төлөвлөгөөнд 2016, 2017 онуудад 1,308.7- 2,910.6 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж, 3,079.8-3,650.1 тэрбум төгрөгийн төслийн орлогоос эргэн төлөгдөх зээл олгохоор тус тус төлөвлөж байжээ.

2.2 МУХБ нь 2012-2017 онд нийт 2,254.7 тэрбум төгрөгийг 4.0-4.79 хувийн хүүтэйгээр, 30.0 тэрбум иенийг 1.52 хувийн хүүтэйгээр, 1,502.2 сая ам.долларыг 2.5-9.5 хувийн хүүтэйгээр, 33.0 сая еврог 1.9-6.39 хувийн хүүтэйгээр тус тус татан төвлөрүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү/

2.3 ЭЗХЯ, Монголбанк, Сангийн яамны 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 05/12/445 дугаар бүхий гэрээ байгуулж, Чингис бондын 1.49 тэрбум ам.долларыг Монголбанк дахь Засгийн газрын бондын харилцах дансанд жилийн 4.7917 хувийн хүүтэй байршуулж, Монголбанк нь Сангийн яаманд сард 5.9 сая ам.долларын хүү төлж байжээ.

2.4 Сангийн яам нь 2013 онд Чингис бондын эх үүсвэрээс 1,224.7 сая ам.долларыг МУХБ-нд төгрөгөөр байршуулснаас 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд нийт 761.1 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн гэх тооцоо гарч байна.

2.5 Хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүйгээс татан төвлөрүүлсэн зарим эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй байсан төдийгүй МУХБ мөнгөн хөрөнгийг зохистой удирдаж ажиллаагүйгээс нийт 17.9 сая ам.долларын үр ашиггүй зардал гаргаж, 16.0 сая ам.долларын орлого олох боломжийг алджээ. Үүнд:

- Евро бондын 20.0 сая ам.долларыг аливаа төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, арилжааны банкнуудад хадгаламж хэлбэрээр байршуулах зэрэг арга хэмжээ аваагүй бөгөөд 2012 оны 6, 12 дугаар саруудад хүүгийн зардалд тус бүр 0.6 сая ам.доллар нийт 1.2 сая ам доллар төлсөн;
- Евро бондын 580.0 сая ам.долларыг 2012 оны 9 дүгээр сараас арилжааны банкнуудад хадгаламж хэлбэрээр байршуулах, 2012 оны 10 дугаар сараас зээл олгох зэргээр ашиглаж эхэлсэн бөгөөд ашиглаагүй хугацаанд хүүгийн зардалд 16.7 сая ам.доллар төлсөн;
- Евро бондын 580.0 сая ам.долларыг 2012 оны 3 дугаар сараас 9 дүгээр сар хүртэлх 6 сарын хугацаанд зээл олгох, арилжааны банкнуудад хадгаламж хэлбэрээр байршуулах зэргээр зохистой удирдсан бол 16.0 сая ам.долларын орлого олох боломжтой байжээ.

2.6 Зарим эх үүсвэрийн нэрлэсэн хүүгийн түвшин бага байгаа хэдий ч бонд гаргахтай холбоотой зардал, баталгааны зардал, шимтгэлийн дүн зэрэг гэрээний дагуу суутгагдах зардал нь бондын дүнгийн 0.4-23.0 орчим хувийг эзэлж, бодит хүү өсөхөд хүргэж байна. Тухайлбал,

- Самурай бондын нэрлэсэн хүү 1.52 хувь хэдий ч Японы олон улсын хамтын ажиллагааны банкны баталгааны зардал нь 5.7 тэрбум иен буюу бондын дүнгийн 19 орчим хувь, нийт зардал 23 орчим хувийг эзэлж бодит хүүг 4.39 хувь;
- Внешэкономбанкны 20.0 сая ам.долларын дамжуулан зээлийн нэрлэсэн хүү 2.88 хувь хэдий ч нийт зардал шимтгэл 1.3 сая ам доллар буюу зээлийн 6.7 орчим хувийг эзэлж, бодит хүү 5.03 хувь болж байна.

2.7 Монгол Улсын зээлжих зэрэглэлээс хамаарч татан төвлөрүүлсэн эх үүсвэр буцаан дуудагдах, хүүгийн түвшин өөрчлөгдөх эрсдэлтэй байгаа тул цаашид эх үүсвэр татан төвлөрүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Тухайлбал,

- Credit Suisse, SMBC, Эксим банк зэргийн хамтарсан зээлийн 300.0 сая ам.долларыг 5.71-5.84 хувийн хүүтэйгээр 3 жилийн хугацаатай татан төвлөрүүлсэн бөгөөд 2016 оны 8 дугаар сард Стандарт энд Пүүрс байгууллага Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "В" байснаас "В-" гэж үнэлсэн, Мүүдийс агентлаг "В2" байснаас "В3" болгон үнэлсэн нь эх үүсвэр буцаан татагдах нөхцөлд хүргэжээ;
- МУХБ нь зээлдэгч нарт гэрээний дагуух эргэн төлөлт шаардахгүй байх тухай "үүргээс чөлөөлөх албан хүсэлт"-ийг хүргүүлэн зээлийг эргүүлэн төлөхөөс чөлөөлүүлж, зээлийн хүүг 0.25 хувиар нэмэгдүүлсэн байна.



2.8 Сангийн яам нь 2017 онд Засгийн газраас баталсан хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор Төсвийн тогтворжуулалтын сангаас МУХБ-нд хөрөнгө байршуулахдаа 7.5-10.875 хувийн хүүтэй байршуулсан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9¹.8²⁷-д заасныг зөрчсөн байна.

- Арилжааны банкнуудын хадгаламжийн хүүгийн түвшин дунджаар 12 орчим хувьтай байхад Сангийн яам нийт 98.0 тэрбум төгрөгийг МУХБ-нд 7.5-10.875 хувийн хүүтэйгээр 2017 оны 5 дугаар сарын 04-ний өдрөөс он дуустал үе шаттайгаар байршуулснаас Сангийн яам 1.1 тэрбум орчим төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алджээ.

2.9 БНХАУ-ын Эксим банкны Зээлийн хорооноос тавьсан нөхцөлийг бүрэн хангасан тохиолдолд Шинэ яармаг орон сууцны хорооллын төслийг хэрэгжүүлэхэд зээл олгох боломжтой гэсэн шийдвэрийг БНХАУ-ын Эксим банк гаргасан хэдий ч төсөл хэрэгжүүлэгч компани уг нөхцөлийг бүрэн хангаагүйгээс эх үүсвэрийг ашиглах боломжгүй байдал үүссэн байна.

- Засгийн газрын тогтоолоор Нийслэлийн гэр хорооллыг орон сууцжуулах зорилтын хүрээнд “Шинэ яармаг орон сууцны хорооллын төсөл”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах 188.2 сая хүртэлх ам.долларын зээлийг БНХАУ-ын Экспорт-Импорт банкнаас авч “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-аар дамжуулан төсөл хэрэгжүүлэгчид зээлдүүлэхийг МУХБ-нд зөвшөөрсөн.
- БНХАУ-ын Эксим банк төслийн санхүүжилтийн 15 хувийг төсөл хэрэгжүүлэгч “Нью яармаг хаусинг прожект” ХХК өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдсэн 85 хувь буюу 109.6 сая ам.долларыг МУХБ-аар дамжуулан олгох шийдвэрийг 2015 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар гаргасан боловч уг эх үүсвэрийг ашиглаж чадаагүй байна.

2012-2015 онд мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс их хэмжээний орлого олох боломжийг алдаж, 102.1 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн байна

2.10 МУХБ нь ОХУ-ын ВТБ банкны зээлийн шугамын эхний санхүүжилт болох 65.4 сая ам долларыг 2016 оны 12 дугаар сард, Чингис бондын 2,021.3 тэрбум төгрөг, 269.9 сая ам.долларыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Сангийн яамнаас авах авлагын дүнд харилцан суутгах замаар 2017 оны 1 дүгээр сард, Евро бондын 580.0 сая ам.долларын эргэн төлөлтийг Хуралдай бондын хөрөнгөөр 2017 оны 3 дугаар сард тус тус төлж барагдуулсан байна.

2.11 Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолыг үндэслэн Япон улсын үнэт цаасны зах зээлд арилжаалсан Самурай бондын 30.0 тэрбум иенийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан ханшийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авалгүйгээр бусад валютад шилжүүлснээс 2014-2017 онд 102.1 тэрбум төгрөгийн ханшийн тэгшитгэлийн алдагдал хүлээсэн байна.

Хүснэгт 10. Ханшийн тэгшитгэлийн алдагдал /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2012/12/31	2013/12/31	2014/12/31	2015/12/31	2016/12/31	2017/12/31	Нийт
Ханшийн тэгшитгэлийн цэвэр ашиг/ алдагдлын гүйцэтгэл	(5.7)	1.9	53.1	(24.9)	(157.6)	(25.8)	(159.0)
JPY	-	-	47.4	(18.40)	(120.7)	(10.4)	(102.1)
USD	(5.7)	1.9	5.8	(10.24)	(14.37)	(10.0)	(32.6)
EUR	-	-	(0.4)	3.71	(22.57)	(5.48)	(24.7)
CNY	-	-	-	0.00	0.01	0.13	0.1

Эх сурвалж: МУХБ

2.12 Иений ханшийн тэгшитгэлийн алдагдал нь 2016 оны жилийн эцсийн байдлаарх нийт ханшийн тэгшитгэлийн алдагдлын 76.6 хувь буюу 120.7 тэрбум төгрөг байсан бөгөөд голлох валютын сүүлийн 1 жил гаруй хугацааны ханшийн харьцангуй тогтвортой байдал, МУХБ-наас

²⁷ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 9¹.8. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийг хүүгийн түвшин нь арилжааны банкны тухайн жилийн хадгаламжийн хүүгийн түвшнээс багагүй байх санхүүгийн хэрэгсэлд байршуулна.



хэрэгжүүлсэн активын удирдлагын үр дүнд 2017 онд 40.3 хувь буюу 10.4 тэрбум төгрөг болж буурсан байна.

2.13 МУХБ-наас 2012-2017 онд арилжааны банкнуудын хадгаламж, ЗГҮЦ зэрэгт байршуулсан мөнгөн хөрөнгө, татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 11. Мөнгөн хөрөнгийн цэвэр үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015	12/31/2016	12/31/2017
Монголбанк, Засгийн газрын үнэт цаас	-	-	-	166,742.3	1,038,119.1	-
Харилцах	31,358.1	21,273.2	2,370.2	112,452.6	70,409.5	128,353.8
Хадгаламж	319,993.2	819,500.0	1,271,565.0	732,665.7	188,004.3	1,003,982.9
Татан төвлөрүүлсэн хөрөнгө /дотоод/	-	117,127.0	122,564.0	223,497.1	59,748.7	482,998.9
Цэвэр дүн /хадгаламж/	319,993.2	702,373.0	1,149,001.0	509,168.6	128,255.6	520,984.0
Нийт байршуулсан хөрөнгө	351,351.3	723,646.2	1,151,371.3	788,363.5	1,236,784.3	649,337.7

Эх сурвалж: МУХБ

2.14 МУХБ нь Монгол Улсын 2010-2013 оны Төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвөөс 16.7-123.0 тэрбум төгрөгөөр дүрмийн сангаа бүрдүүлсэн боловч уг хөрөнгийн удирдлага хангалтгүй, дансанд сул байлгаж 1.2-2.2 тэрбум орчим төгрөгийн орлого олох боломжийг алджээ.

2.15 МУХБ-ны удирдлага мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүй нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд /2011 он, 2017 он/ заасан ашигтай ажиллах зарчмыг хангаж ажиллаагүй, их хэмжээний орлого олох боломжийг алдахад хүргэсэн байх тул дараах асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай гэж үзэв. Үүнд:

- ЗГҮЦ-ны өгөөж 2014 оны 10 дугаар сард 15.538-16.15 хувь байхад Улаанбаатар хотын банк, Худалдаа хөгжлийн банкны эзэмшиж байсан 11.0-11.5 хувийн хүүтэй нийт 55.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ыг худалдан авснаас 1.7 тэрбум төгрөгийн орлого олох боломж;
- 2012-2017 оны хугацаанд арилжааны банкнуудад зарим төгрөгийн хадгаламжийг Монгол банкны бодлогын хүүгийн түвшнээс 0.05-5.25 пунктээр бага хүүтэйгээр байршуулснаас нийт 17.3 тэрбум төгрөг, ам.долларын хадгаламжийг эх үүсвэрийн хүүгийн түвшнээс²⁸ 0.25-3.75 пунктээр бага хүүтэй байршуулснаас нийт 0.9 сая ам.долларын орлого олох боломжийг тус тус алдсан гэсэн тооцоолол гарч байна. Тухайлбал:
 - Худалдаа хөгжлийн банкнаас 7.5 хувийн хүүтэй, 232 хоногийн хугацаатайгаар татсан 78.5 сая ам.долларыг Голомт банканд 3 хувийн хүүтэй, 31 хоногийн хугацаатайгаар;
 - Монголбанкны бодлогын хүү 12 хувь байхад Улаанбаатар хотын банканд 117.7 тэрбум төгрөгийг 10.5 хувийн хүүтэй, 178 хоногийн хугацаатайгаар;
 - Монголбанкны бодлогын хүү 10.5 хувь байхад Худалдаа хөгжлийн банканд 179.4 тэрбум төгрөгийг 9.3 хувийн хүүтэй, 94 хоногийн хугацаатайгаар тус тус байршуулсан гэх мэт.

Хүснэгт 12. Мөнгөн хадгаламжийн хүүгийн зөрүүгээс тооцоолсон алдагдсан боломж /сая төгрөг, мянган ам.доллар/

№	Хадгаламжийн төрөл	Хугацаа						Нийт
		2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	
1	Төгрөгийн	1,006.1	3,825.7	12,464.2	23.4	69.3	-	17,388.7
	3 сар хүртэлх хугацаатай	635.9	1,555.8	7,199.4	23.4	69.3	-	9,482.7
	6 сар хүртэлх хугацаатай	59.0	2,269.9	5,153.9	-	-	-	7,482.8
	1 жил хүртэлх хугацаатай	311.2	-	110.9	-	-	-	422.1
2	ам.долларын	421.2	481.2	15.9	-	-	-	918.3
	3 сар хүртэлх хугацаатай	302.7	114.6	15.9	-	-	-	433.2
	6 сар хүртэлх хугацаатай	62.9	366.6	-	-	-	-	429.5
	1 жил хүртэлх хугацаатай	55.6	-	-	-	-	-	55.6

Эх сурвалж: Үндэсний аудитын газар

2.16 Арилжааны банкнуудад мөнгөн хадгаламж байршуулах харилцаа 2015 оны 2 дугаар сарыг хүртэл нарийвчилсан зохицуулалтгүйгээс зарим мөнгөн хадгаламжийн гэрээнд хадгаламжийг бүтнээр болон хэсэгчлэн буцаан татах үед тооцох хүүг үндсэн хүүгээс бага байхаар тусгаж байжээ.

²⁸ МУХБ-ны 2012 онд авсан Евро бондын 580.0 сая ам.долларын 5.75 хувийг жишиг хүү болгон тооцов



2.17 МУХБ арилжааны банкнуудад байршуулсан мөнгөн хадгаламжийг үндэслэлгүйгээр хугацаанаас нь өмнө буцаан татсан, мөнгөн хадгаламжийг буцаан татах үеийн хүүгийн зөрүүг хамгийн бага түвшинд байлгах бодлого баримтлаагүй зэргээс нийт 3.5 тэрбум төгрөг, 168.0 сая иений хүүгийн орлого олох боломжийг алдсан гэсэн тооцоолол гарч байна. Тухайлбал,

- Арилжааны банканд 1-9 хоног байршиж буй хадгаламжаас буцаан дуудах замаар хүүгийн зөрүүг бууруулах боломжтой байхад 4-218 хоног байршсан нийт 98.5 тэрбум төгрөгийн 29 мөнгөн хадгаламжийг буцаан татсанаас нийт 1.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан,
- 2013, 2014 онд нийт 121.7 тэрбум төгрөгийн 26 мөнгөн хадгаламж, 10.0 тэрбум иений 2 мөнгөн хадгаламжийг хугацаанаас нь өмнө буцаан татсанаас шалтгаалж 1.9 тэрбум төгрөг, 168.0 сая иений хүүгийн орлого олох боломжийг тус тус алдсан бөгөөд хадгаламж буцаан татсан тухайн өдрүүдэд МУХБ-аас бусад арилжааны банкнуудад нийт 584.2 тэрбум төгрөг, 9.9 тэрбум иений мөнгөн хадгаламж байршуулж байсан нь буцаан татах хэрэгцээ шаардлага байгаагүйг харуулж байна.

2.18 МУХБ-ны Эрсдэлийн удирдлагын газраас арилжааны банкнуудад хадгаламж байршуулах харилцааг Гүйцэтгэх захирлын 2015 оны А/16 дугаар тушаалаар баталсан “МУХБ-наас арилжааны банкнуудад хадгаламж байршуулах, татан төвлөрүүлэх журам”-ын дагуу сар бүр арилжааны банкнуудын санхүүгийн байдалд эрсдэлийн үнэлгээ, тухайн арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн дээд хэмжээ зэрэг хязгаарлалтыг тооцож, АПУГ-т журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай зөвлөмжийг хүргүүлж байсан байна.

2.19 Гэвч уг хязгаарлалтыг тухай бүр мөрдөлгүйгээр зарим банканд тогтоосон хязгаарыг хэтрүүлэн хадгаламж байршуулж ирсэн нь МУХБ-ны банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонирхлын зөрчилтэй албан тушаалтан ажиллаж байсантай холбоотой байх магадлалтай байна. Тухайлбал,

- 2013- 2016 онд нийт мөнгөн хадгаламжийн 43.4-86.4 хувь нь зөвхөн Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банканд төвлөрч байсан бөгөөд Улаанбаатар хотын банканд байршуулах мөнгөн хадгаламжийн дээд хэмжээг 2015 оны 1-12 дугаар саруудад 144.4-186.5 тэрбум төгрөгөөр, 2016 оны 1-10 дугаар саруудад 31.1-153.9 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн байршуулж, дээрх журмын 3.1.4²⁹ дэх заалтыг зөрчсөн,
- Худалдаа хөгжлийн банканд байршуулах мөнгөн хадгаламжийн дээд хэмжээг 2015 оны 1-3 дугаар саруудад 18.6-140.0 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн байршуулсан нь журмын 3.1.4 дэх заалтыг зөрчсөн эдгээр зөрчил нь Улаанбаатар хотын банкны тэргүүн дэд захирал ажиллаж байсан О.Банзрагч МУХБ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр давхар ажиллаж байсантай холбоотой байж болзошгүй байна,
- ЭУГ-аас тогтоосон үнэлгээгээр 4-өөс доош үнэлгээтэй байсан Капитал, Капитрон, Чингис хаан банкнуудад байршуулах мөнгөн хадгаламжийн дээд хэмжээг 2015-2016 оны зарим саруудад 4.6-34.0 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн хадгаламж байршуулсан нь “Арилжааны банкны санхүүгийн байдалд эрсдэлийн үнэлгээ хийх, мөнгөн хадгаламж байршуулах, хэмжээ тогтоох аргачлал”-ын 2.7³⁰ дахь заалтын дагуу гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, журмын 3.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

2.20 “МУХБ-наас арилжааны банкнуудад хадгаламж байршуулах, татан төвлөрүүлэх журам”-ыг Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн А-69/1 дүгээр тушаалаар хүчингүй болгож арилжааны банкнуудад байршуулах мөнгөн хадгаламжийн дээд хэмжээ буюу хязгаарлалтыг тухайн банкны нийт активын 10.0 хувь болгон тогтоожээ.

2.21 Журам хүчингүй болсноор хадгаламжийн дээд хэмжээ тогтоосон хязгаарлалтыг эс тооцвол арилжааны банкнуудад хадгаламж байршуулах үйл ажиллагааг зохицуулсан зохицуулалт байгаагүй бөгөөд Гүйцэтгэх захирлын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А-269 дүгээр тушаалаар журам³¹ шинэчлэн батлагдаж, дээрх хязгаарлалт тухайн банкны нийт активын 12 хувь байхаар тогтоосныг АПУХГ үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2.22 Уг журамд Монголбанкнаас тавьсан шалгуурыг хангаж буй арилжааны банканд хадгаламж байршуулахдаа “хадгаламжийн хүүгийн түвшин, байршуулах хугацаа нь бусад мөнгөн хадгаламжийн нөхцөлтэй харьцуулагдахуйц байх” гэсэн ч хэрхэн тооцох нь тодорхойгүй байгааг шинэчлэх шаардлагатай байна.

²⁹ МУХБ-наас арилжааны банкнуудад хадгаламж байршуулах, татан төвлөрүүлэх журмын 3.1.4 нэг арилжааны банканд байршуулах хөрөнгийн хэмжээг ЭУГ-ын арилжааны банкуудын эрсдэлийн үнэлгээгээр тогтоосон дүнгээс хэтрүүлэн байршуулах болон арилжааны банкнаас байршуулсан хөрөнгийг бүрэн татах үйл ажиллагааг АПУХ-ны хурлаар хэлэлцэн шийдвэр гаргасны үндсэн дээр зохицуулна.

³⁰ 2.7 Энэ аргачлалаар тооцсон эрсдэлийн үнэлгээ 4-с бага тохиолдолд тухайн банканд байршуулсан мөнгөн хадгаламжийг эргүүлэн татах болон нэмж мөнгөн хадгаламж байршуулахгүй байх талаар зөвлөмжийг эрсдэлийн үнэлгээ тооцсон тайлангийн хамт АПУГ, АПУХ-нд хүргүүлэн танилцуулна.

³¹ Мөнгөн хадгаламж байршуулах үйл ажиллагааны журам



2.23 Арилжааны банкнаас МУХБ-нд бичиж өгч буй байршсан хадгаламжийн дүн бүхий энгийн вексель нь Векселийн тухай хуулийн 15.1³²-д заасан батлан даагчгүй байгаа нь хадгалагч банк төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд векселийг хэрхэн мөнгөжүүлэх асуудал тодорхой бус, үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломжгүй нөхцөл үүсэх эрсдэл бодитойгоор оршиж байна.

2.24 Засгийн газрын шийдвэрээр хөтөлбөрийн хүрээнд 2012-2016 онд олгосон зарим зээлийн хүү нь эх үүсвэрийн хүүгээс бага байгаагаас МУХБ-нд зөвхөн нэг жилд 4.1 тэрбум төгрөг, 1.2 сая ам.долларын алдагдал хүлээхээр тооцоо гарч байгаа нь МУХБ-ны тухай 2017 оны хуулийн 7.1.1-т заасан ашигтай ажиллах зарчимтай нийцэхгүй байна. Тухайлбал:

Хүснэгт 13. Хүүгийн зөрүү бүхий хөтөлбөрүүд

№	Хөтөлбөр	Эх үүсвэр	Эх үүсвэрийн хүү /хувь/	Зээлийн хүү /хувь/	Хэмжих нэгж	Олгосон санхүүжилт	Нэг жилээр тооцолсон хүүгийн хэмжээ*		
							Эх үүсвэрийн хүүгийн зардал	Зээлийн хүүгийн орлого	Хүлээх алдагдал
	1	2	3	4	5	6	7	8	7-8=9
1	Авто замын төслүүд	Кредит Свисс хамтарсан зээлийн эх үүсвэр	4.5 хувь + 6М лайбор /бодит хүү 6.28 хувь/	6.13	тэрбум төгрөг	82.9	5.2	5.1	0.1
2	Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр-300 тэрбум			6	тэрбум төгрөг	119.8	7.5	7.2	0.3
3	Арьс шир хөтөлбөр			5	тэрбум төгрөг	68.8	4.3	3.4	0.9
4	ЖДҮ-70.0 хөтөлбөр			6	тэрбум төгрөг	63.4	4.0	3.8	0.2
5	Экспортыг дэмжих хөтөлбөр /2.0 тэрбумаас дээш/ 888 төсөл			5	тэрбум төгрөг	150.0	9.4	7.5	1.9
6	Кью Эс Си ХХК	Каргилл санхүүгийн байгууллагын зээл	9.5	8	сая ам.доллар	71.3	6.8	5.7	1.1
7	Шинэ төмөр зам төсөл			7.37	сая ам.доллар тэрбум төгрөг	4.6 3.7	0.4 0.4	0.3 0.3	0.1 0.1
8	Экспортыг дэмжих хөтөлбөр /2.0 тэрбумаас доош/ 888 төсөл	Евро бонд	5.75	5	тэрбум төгрөг	75.2	4.3	3.8	0.6
Нийт					тэрбум төгрөг		35.1	31.0	4.1
					сая ам.доллар		7.2	6.0	1.2

Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол, *Ам.доллартой харьцах төгрөгийн ханшийг 2013 оны 12 дугаар сарын 31-ний хаалтын ханшаар авав. /1 ам.доллар = 1,659.34 төгрөг/

2.25 Энэ нь Засгийн газраас төсөл хэрэгжүүлэгчдэд олгох зээлийн хүүгийн түвшнийг тогтоосноос шалтгаалсан бөгөөд Хөгжлийн банк цаашид эх үүсвэрийн хүүгийн түвшинтэй уялдуулан зээлийн хүүгийн түвшинг тогтоож байх шаардлагатай байна.

³² Векселийн тухай хууль 15.1. Төлбөр хариуцагчаас вексeld заасан төлбөр гүйцэтгэхийг батлан дааж, хэрэв уг үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд төлбөр хариуцагчийн өмнөөс төлбөр хийх үүрэг авч байгаа гуравдагч этгээдийг батлан даагч /цаашид "батлан даагч" гэх/ гэнэ. Батлан даагч нь банк, аж ахуйн нэгж байна.